



I-IX/2021

Тархаасан: 2021 оны 11 дүгээр сарын 15



Дотоод худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.7 хувиар буурлаа

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны эхний 9 сард 19.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.4 (22.1%) их наяд төгрөгөөр өслөө.

Үүнд хүнсний бүтээгдэхүүн, шатахууны бөөний болон жижиглэн худалдаа, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа, моторт тээврийн хэрэгслийн сэлбэг эд ангийн худалдаа, эм, гоо сайхан, ариун цэврийн барааны худалдаа тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны 9 дүгээр сард 2.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 16.3 (0.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО¹, жил бүрийн эхний 9 сард


	2019*		2020*		2021*		2021* I-IX 2020* I-IX
	IX	I-IX	IX	I-IX	IX	I-IX	
	тэрбум төгрөг						хувь
Нийт	1 924.5	16 901.6	1 985.6	15 555.4	2 368.2	18 993.7	122.1
Бөөний худалдаа	692.8	6 132.3	761.7	5 759.5	859.4	7 241.4	125.7
Жижиглэн худалдаа	1 231.7	10 769.3	1 224.0	9 796.0	1 508.8	11 752.3	120.0

¹ Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

2021 оны эхний 9 сард худалдааны салбарын борлуулалтын орлогын 38.1 хувь нь бөөний худалдаа, 61.9 хувь жижиглэн худалдааны салбарт ногдож, өмнөх оны мөн үеэс бөөний худалдааны орлогын дүнд эзлэх хувь 1.1 нэгж хувиар өсөж, жижиглэн худалдааны орлогын дүнд эзлэх хувь 1.1 нэгж хувиар буурсан байна.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2021 оны эхний 9 сард 11.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.0 (20.0%) их наяд төгрөг, бөөний худалдааны борлуулалтын орлого 7.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.5 (25.7%) их наяд төгрөгөөр тус тус өслөө.


ЗУРАГ 1. ХУДАЛДААНЫ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, сараар, тэрбум төгрөг



Худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны 9 дүгээр сард өмнөх сараас 16.3 тэрбум төгрөгөөр буурахад шатахууны бөөний болон жижиглэн худалдаа, хүнсний бөөний худалдаа буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 83.5 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалтын орлого 2021 оны эхний 9 сард 15.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.9 (22.1%) их наяд төгрөгөөр өслөө.

ЗУРАГ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, аймгаар, жил бүрийн эхний 9 сард, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Худалдааны нийт үйлдвэрлэлд бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) -г оруулна.

Худалдааны салбарын нийт борлуулалт нь тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, Дотоод худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын сарын мэдээ, НӨАТ төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархаах хуваарь:

2021 оны 12 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын статистикч Л.Энхбаатар
Утас: (976-51)-264797

